



**“ТҮНШЛЭЛИЙН АЧ ХОЛБОГДОЛ МИНИЙ НҮДЭЭР”**  
**СЭДЭВТ**  
**ОЮУТНУУДЫН ВИДЕО ИЛТГЭЛИЙН УРАЛДААН**  
**[English version below]**

## **ҮНДЭСЛЭЛ**

Монгол Улс АХБ-нд гишүүнээр элссэний 30 жилийн тэмдэглэлт ой энэ онд тохиож буйтай холбогдуулан тус банкнаас хамтран ажиллагч талуудын хамтаар түншлэлийн түүхээ эргэн харж, ололт амжилтаа бататган, хуримтлуулсан туршлага, сургамжаа хуваалцан, цаашдын хамтын ажиллагааны чиглэлээ тодорхойлох арга хэмжээнүүдийг бүтэн жилийн турш зохион байгуулахаар төлөвлөж байна.

Энэ хүрээнд АХБ-ны Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газраас нийт бакалаврын түвшний оюутнуудын дунд шилдэг илтгэлийн уралдааныг зарлаж байна.

## **УРАЛДААНЫ СЭДЭВ**

“Түншлэлийн ач холбогдол миний нүдээр”

- Улс орны хөгжилд түншлэл яагаад чухал вэ?
- Оюутан би, Монгол Улсын иргэний хувьд хөгжлийн түншлэлд хэрхэн хувь нэмрээ оруулах вэ?

## **ЗОРИЛГО**

- Хөгжлийн түншлэлийн ач холбогдлыг өөрийн өнцгөөс томъёолон гаргаж, илэрхийлэх боломжийг оюутан, залууст олгох;
- Тогтвортой хөгжлийг цогцлоохын тулд түншлэлийн үр нөлөөг хэрхэн сайжруулах талаар болон хөгжлийн түншлэлээс залуучууд юуг хүсдэг тухай хэлэлцүүлэг өрнүүлэх.

## **УРАЛДААНЫ ДҮРЭМ, ШААРДЛАГА**

- Монгол Улсын их, дээд сургуулийн Бакалаврын түвшинд суралцаж буй оюутнууд уралдаанд оролцох боломжтой.
- Бүртгэлийн хураамжгүй.
- Оюутнууд урьдчилан бэлтгэсэн аман илтгэлээ 3-4 минутын видео бичлэг хэлбэрээр илгээж уралдаанд оролцоно.
- Илтгэл нь Монгол эсвэл Англи хэл дээр байна.
- Нэг оролцогч нэг бүтээлээр оролцох боломжтой.
- Уралдаанд ирүүлэх илтгэлийг өгөгдсөн сэдвийн хүрээнд бэлтгэсэн байна.
- Илтгэлийг оюутан өөрөө бэлтгэсэн байх. Ингэхдээ багшаас санал зөвлөмж авч болно.
- Илтгэлийн видео дүрсэнд оюутан өөрийн биеэр харагдаж байх.

- Илтгэлийн эхэнд оролцогч өөрийн нэр болон суралцдаг сургуулийг дурдах.
- Өндөр нягтаршилтай бичлэг илгээх нь илүү тохиромжтой. Боломжгүй тохиолдолд оролцогч дүрсийг аль болох тод гаргахад анхаарах.
- Бичлэг нь гадаад орчны чимээ, дуу шуугиангүй байх.
- Оролцогч нь бичлэгээ ямар нэгэн “shared drive”-д байршуулж, URL холбоосыг имэйлээр илгээнэ.
- Зохиогчийн эрхтэй барааны тэмдэгт, компанийн нэр, дуу, хөгжим, аяз, лого зэргийг ашиглахгүй байх.
- Илтгэл нь зүй бус агуулга, бүдүүлэг, доромж үг хэллэг, хэн нэгний нэр төрд халдсан үг, өгүүлбэр, худал мэдээлэл агуулаагүй байх.
- Илтгэл нь аливаа худалдаа, бизнесийн шинжтэй агуулгагүй байх.

## БҮТЭЭЛ ХҮЛЭЭН АВАХ

Бүтээлийг **2021 оны 4-р сарын 23-ны өдрийн 22 цаг** хүртэл [adbmongolia30@gmail.com](mailto:adbmongolia30@gmail.com) имэйл хаягаар хүлээн авна. Бүтээлээ ирүүлэхдээ имэйлийн гарчиг хэсэгт “Илтгэлийн уралдаанд” гэж хаяглана уу. И-мэйлд дараах мэдээллийг дурдсан байх, үүнд:

- Уралдаанд оролцогчийн нэр
- Утасны дугаар
- Их, дээд сургуулийн нэр, мэргэжил, курс
- Видео илтгэлийг хадгалсан URL холбоос
- Илтгэлийн талаарх товч танилцуулга (текст хэлбэрээр)

## ШАЛГАРУУЛАЛТ

АХБ-ны удирдлага болон бие даасан экспертүүдээс бүрдэх үнэлгээний баг бүтээлүүдийг шүүж, шилдэг бүтээлийг шалгаруулна. Шилдэг бүтээлийн эздийг 2021 оны 5 дугаар сарын дундуур зарлана.

Бүтээлүүдийг хөндсөн асуудлын ач холбогдол, илэрхийлэл, бүтээлч хандлага болон шинэлэг байдал, илтгэх ур чадвар, илтгэлийн чанар, цаг ашиглалт гэсэн шалгууруудаар дараах харьцаагаар үнэлнэ.

Шалгуур	Эзлэх хувь
Хөндсөн асуудлын ач холбогдол, түүнийг илэрхийлсэн байдал	20%
Бүтээлч хандлага болон шинэлэг байдал	20%
Илтгэх ур чадвар	20%
Илтгэлийн чанар (илтгэл бэлтгэхэд зориулсан судалгаа)	20%
Цаг ашиглалт	20%

Бүтээлийн шаардлагыг хангаагүй, бүрэн бус бүтээлийг үнэлэхгүй.

## ШАГНАЛ

1. **Нэгдүгээр байр:** 2,000,000 төгрөг
2. **Хоёрдугаар байр:** 1,500,000 төгрөг
3. **Гуравдугаар байр:** 1,000,000 төгрөг
4. **Тусгай байр:** АХБ-ны санхүүжилтээр Улаанбаатар хотод хэрэгжиж буй төслүүдээс сонгон газар дээр нь очиж танилцах эрхийг шилдэг 10 оролцогчид олгоно

Шилдэг оролцогчдыг 2021 оны тавдугаар сард болох шагнал гардуулах ёслолд урьж, аравдугаар сард болох Монгол Улс АХБ-нд гишүүнээр элссэний 30 жилийн ойн үйл ажиллагааны үндсэн арга хэмжээнд оролцох эрхээр урамшуулна.

## **ОЮУНЫ ӨМЧ**

АХБ энэхүү уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг татаж авах, хуулбарлаж авах эрхтэй.

АХБ энэхүү уралдааны ялагчдын мэдээллийг ирүүлсэн бүтээлийн хамт өөрийн веб хуудас, хэвлэл, баримт бичиг, бусад хэрэгсэл дээр тавих, дурдах эрхтэй.

Уралдаанд видео илтгэлээ ирүүлсэн оролцогч уг бүтээлийг тухайн оролцогчийн өөрийн эх бүтээл бөгөөд хэн нэгний бүтээлээс хуулбарлаагүй, аливаа хувь хүн болоод хуулийн этгээдийн оюуны өмчийн эрхийг зөрчөөгүй хэмээн нотолсон гэж үзнэ.

## **УРАЛДААНЫГ ЦУЦЛАХ, ХҮЧИНГҮЙ БОЛГОХ**

АХБ нь шаардлагатай тохиолдолд уралдааныг цуцлах, өөрчлөлт оруулах эрхтэй.

АХБ аливаа бүтээлийг хүлээж авах, үнэлгээний шатанд оруулахаас татгалзах эрхтэй.

Оролцогч нь уралдаанд бүтээлээ ирүүлснээр тэмцээний бүх дүрэм, шаардлагатай танилцаж, хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

Оролцогч нь уралдаанд бүтээлээ ирүүлснээр өөрийн мэдээллийг энэхүү уралдааны хүрээнд ашиглаж болохыг хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ.

Уралдаанд бэлтгэх болон бүтээлээ ирүүлэхтэй холбоотой гарсан аливаа зардлыг АХБ хариуцахгүй.

Энэхүү удирдамжид заасан аливаа зүйл, заалт нь АХБ-ыг байгуулах гэрээ болон бусад Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээрээр баталгаажсан АХБ-ны эрх ямбыг хөндөхгүй болно.

\*\*\*\*\*

Уралдааны талаар тодруулга авах бол [adbmongolia30@gmail.com](mailto:adbmongolia30@gmail.com) имэйл хаягаар хандана уу.

**УРАЛДААНД ОРОЛЦОХООР СОНИРХОЖ БУЙ ТАНД БАЯРЛАЛАА.**

**Амжилт хүсье!**

[\[English version below\]](#)



**MONGOLIA**  
**ADB@30**



Partnering  
Developing  
Innovating

**PUBLIC SPEAKING COMPETITION AMONG STUDENTS  
on  
"IMPORTANCE OF PARTNERSHIP THROUGH MY EYES"**

**OVERVIEW**

The Asian Development Bank (ADB) has been partnering with Mongolia since 1991, supporting the country's development priorities. Over the past 30 years, ADB has developed a strong relationship with its key stakeholders in Mongolia.

This year, 2021, marks the 30th anniversary of the ADB–Mongolia partnership. To ensure successes are well understood and that lessons are learned, ADB plans to commemorate the anniversary through a series of events and activities that will aim to trigger innovation and a commitment to further deepen and broaden the relationship.

As part of the series, ADB's Mongolia Resident Mission (MNRM) is pleased to announce a nationwide public speaking competition among undergraduate students.

There is no fee to enter the competition.

**TOPIC**

**Importance of partnership through my eyes**

- Why partnership matters to development?
- What type of partnership am I involved in as a student and a citizen of Mongolia?

**PURPOSE**

The competition aims to provide an opportunity for students to articulate their ideas and thoughts about the importance of development partnership and to engage them in a discussion on (i) how to improve the effectiveness of development cooperation for sustainable impact, and (ii) the youth's expectation from the development partnership.

**COMPETITION RULES AND REQUIREMENTS**

- The competition is open to all undergraduate students with Mongolian nationality.
- There is no fee to enter the competition.
- Students must submit their oral speech style presentation in a pre-recorded video with the length of 3-4 minutes.
- The speech could be in Mongolian or English.
- Only one submission per participant will be accepted.
- Speeches must cover the competition topic.
- Speeches should be original work, developed by the participant. Prior consultations with professors or professional coaches are encouraged.
- Participant must be clearly visible in the video.

- Participant should state his/her name and college or university affiliation in the beginning of the video.
- Videos are preferred to be recorded in high definition. If the participant does not have a device that records in high definition, he/she must ensure that the video is clearly recorded.
- The audio must be clearly recorded without echo, static, or other excessive noise.
- Participant must place the video on a shared drive and send the URL to the designated email address.
- Entries must not violate third-party rights, including, but not limited to copyrights, trademarks, and rights of publicity. Do not use any third-party trademarks, company names, music, or logos.
- Entries must not include unsuitable/unlawful content; obscenity; disparagement; defamation; libel threats; harassment; racial, ethnic, or sexual slurs; other offensive conduct or material as determined by ADB's sole discretion.
- Entries must not include or contain advertising or solicitations of business.

## SUBMISSION

All entries must be submitted by email to [adbmongolia30@gmail.com](mailto:adbmongolia30@gmail.com) no later than **10 p.m. on 23 April 2021**. Please indicate "Public Speaking Competition 2021" in the subject line of your email. Email must include the following details:

- Participant's name
- Phone number
- University affiliation and major
- Year of a program
- URL of the video speech
- Short description of speech in MS Word file

## EVALUATION

The winning entries will be selected by a panel comprised of ADB management and independent experts. The winner will be notified by email by mid-May 2021.

Entries will be scored on their significance and expressiveness, originality and creativity, presentation skill, quality, and utilization of time:

Criteria	Weight
Significance and expressiveness	20%
Originality and creativity	20%
Presentation skill	20%
Quality of speech (amount of work involved in preparation)	20%
Utilization of time	20%

Incomplete, inaudible, and incomprehensible entries will be disqualified.

## PRIZE

1. **Grand prize:** MNT2,000,000 for one student
2. **Second prize:** MNT1,500,000 for one student
3. **Third prize:** MNT1,000,000 for one student
4. **Special recognition:** 10 students will be invited to join a mission and a field visit to ADB project sites in Ulaanbaatar.

Winners will be recognized at the award ceremony in May 2021.

\*The winners will be invited to a high-level commemorative event for the 30th anniversary of the ADB–Mongolia partnership.

## **INTELLECTUAL PROPERTY**

ADB shall have the right to download and make copies of all entries for purposes of this competition.

ADB reserves the right to edit and publish the identities and entries of the winners and the runners-up on its website, publications, documents, or any other dissemination medium. ADB will also own the intellectual property rights to these entries.

By submitting a video, participants affirm their entries are their own original work, have not been copied from others, and do not violate intellectual property rights of any other person or entity.

## **DISCLAIMER**

ADB reserves the right to cancel or modify the competition at any time at its sole discretion.

ADB reserves the right to refuse or disqualify any entry at any time at its sole discretion.

By entering this competition, entrants declare that they have read and accepted the competition rules, and agree to accept the decisions of ADB as final and binding.

By entering this competition, entrants consent to have their submitted personal information used and retained by ADB in accordance with its rules and policies.

ADB will not be liable to reimburse any expenses incurred during the preparation for the competition.

Nothing in this document may be construed as a waiver of any of the privileges, and immunities and exemptions of accorded to the Asian Development Bank under the Agreement Establishing the Asian Development Bank, other instruments, or national or international laws.

\*\*\*\*\*

For further inquiries about the competition, please send an email to [adbmongolia30@gmail.com](mailto:adbmongolia30@gmail.com).

**THANK YOU FOR YOUR INTEREST IN THE PUBLIC SPEAKING COMPETITION.**

**Best of luck!**